



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/330

Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/г,л/, 29.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.10, 42 дугаар зүйлийн 42.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны ээлжит 4 дүгээр хуралдааны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд хүний эрхийг хангах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор, хүний эрхийн талаарх иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, иргэд олон нийтэд сурталчлан таниулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 4500000 /Дөрвөн сая таван зуун мянган/ төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаас /Хууль, эрх зүйн хэлтсийн Хүний эрхийн хангах үйл ажиллагааны зардал/ гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын
15-ны өдрийн 330 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХУУЛЬ,
ЭРХ ЗҮЙН ХЭЛТСЭЭС "ХҮНИЙ ЭРХ"-ИЙГ ХАМГААЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

№	Хийгдэх ажил	Зардал /төгрөг/
1	Хууль, эрх зүйн баримт бичиг, гарын авлага хэвлүүлэх, тараах	4.500.000

-ОоО-